



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/87

Батширээт сум

**Г Золбин нохой устгалын ажлын хэсэг
байгуулах тухай Г**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл ахуйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.15, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтад гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Сумын төвийн золбин нохой устгалын ажлыг 2025 оны 05 дугаар сарын 12-ноос 13-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Золбин нохой устгалыг мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан эрх олгох, зөвлөмжийг захиалагчид өгөх чиг үүрэг бүхий ажлын хэсгийн дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Д.Пүрэвдорж- "Батширээт сум тохижилт"-ын
ОНӨААТҮ-ний газрын захирал

Нарийн бичиг: Б.Бадамгарав- Норовлин багийн Засаг дарга

Гишүүд: Р.Болор-Эрдэнэ- Хэсгийн төлөөлөгч, ахлах дэслэгч

Б.Болд- Байгаль хамгаалагч

Ч.Түшиг- Засаг даргын Тамгын газрын жолооч

3. Утгасан нохойг тусгай цэгт булж ариутгал хийж гүйцэтгэхэд ард иргэдийн аюулгүй байдлыг ханган хяналт тавьж ажиллахыг Хэсгийн төлөөлөгч, ахлах дэслэгч (Р.Болор-Эрдэнэ), гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Пүрэвдорж) нарт тус тус даалгасугай.

4. Золбин нохой устгалын ажлын тайланг танилцуулан ажиллахыг ажлын хэсгийн нарийн бичиг бөгөөд Норовлин багийн Засаг дарга (Б.Бадамгарав)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АЛТАНГЭРЭЛ

202501171